



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 26

Мандалговь

Г

Б.Цагаанчулууг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Болорын Цагаанчулуу 57.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр. Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Цагаанчуулигийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.


ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

131051057

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2020 оны ..., дугаар сарын
15-ны өдрийн 16 дүгээр тогтооолын хавсралт



**Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн
Болорын Цагаанчулууний тухай дүгнэлт**

1. Б.Цагаанчулуу нь 1992 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын төвд төрсөн. 28 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Шинжлэх ухаан технологийн их сургуулийг 2010-2015 онд механик инженерийн бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Хүнсний сүлжээний хөргөлтийн систем мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2018 онд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын ЗДТГ-т нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, 2019-2020 онд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт мэргэжилтнээр ажиллаж байсан.
4. Б.Цагаанчулууний төрийн захирагааны албанд ажиллаж байсан ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ